



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

“ТОХИЖИЛТ-СҮМБЭР” ОНӨААТҮГ-ЫН 2014-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН



Төрийн үйлчилгээг чанартай гүйцэтгэхэд бүтэц, зохион байгуулалтыг тодорхой болгож, санхүүгийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэн ажлын байрны нөхцлийг сайжруулах шаардлагатай байна.

2017 он

Тайланг бэлтгэсэн: Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Ахлах аудитор Ц.Батсайхан 2017 оны 06 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3156 дугаарын утас, 7054-3179 дугаарын факсаар харилцана уу. Байгууллагын хаяг: ГСА Сүмбэр сум 3-р баг, Нутгийн удирдлагын ордон 2-р давхар б корпус 208 тоот	Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Бүлэг 1: Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, мэргэжлийн, чадварлаг боловсон хүчнээр хангагдах, чанартай ажил үйлчилгээ үзүүлэх шаардлагатай байна. 1.1 2014-2016 онд дэвшүүлсэн үйл ажиллагааны зорилго, зорилт нь тодорхойгүй байна. 1.2 Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж чадаагүй байна. 1.3 Үндсэн ажлын чиг үүрэгт хамааралтай ажил үйлчилгээг үзүүлэхэд мэргэжлийн, чадварлаг боловсон хүчин дутагдалтай байна. 1.4 Орлого нэмэгдүүлэх боломжийг судлаагүй, төсөвт 1 төгрөгийн орлого төвлөрүүлэхийн тулд төсвөөс 4.3 төгрөгийн зардал авсан байна. Бүлэг 2: Үйл ажиллагааны үр ашгийг тооцсон зардлын төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй, орлого, зарлагыг дутуу бүртгэж тайлагнаснаар байгууллагын ашиг, алдагдлыг буруу илэрхийлж, жил бүр алдагдлын хэмжээ өссөөр байна. 2.1 Орлого бүрдүүлэх боломжит эх үүсвэрийн судалгаанд үндэслэн орлогын төлөвлөгөөг батлуулаагүй байна. 2.2 Ундны ус худалдан борлуулсны орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлсэнээс орлогын төлөвлөгөө давж биелсэн мэт харагдаж байна. 2.3 Нягтлан бодох бүртгэлд орлогыг үнэн зөв тайлагнаагүй байна. 2.4 Орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлж, үйл ажиллагааны зардалд зарцуулах нөхцөл боломжийг алдсан байна. 2.5 Үйл ажиллагааны үр ашгийг тооцсон зардлын төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй байна. 2.6 Бүтээгдэхүүний өртгийг тооцож ажиллаагүй байна 2.7 Үндсэн үйл ажиллагааны орлогыг бэлнээр зарцуулсан байна. 2.8 Үйл ажиллагааны зардлыг үнэн зөв, бүртгэж тайлагнаагүй байна. 2.9 Жил бүр үйл ажиллагааны алдагдлын хэмжээ өссөөр байна.
--	--

Бүлэг 3: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, хөрөнгийн элэгдлийн зардлыг үнэн зөв тооцож, ажлын байрны нөхцлийг сайжруулах шаардлагатай байна.

3.1 НББОУС-д нийцүүлэн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, элэгдэл байгуулах хувь хэмжээг тогтоогоогүй байна.

3.2 Үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, ашиглалтын шаардлага хангахгүй ажлын байранд үйл ажиллагаагаа явуулж байна.

Бүлэг 4: Дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлээгүй, Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.1 Дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.2 Хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 36.6 хувьтай байна.

4.3 Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Товчилсон үгийн тайлбар

ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГСА	Говьсүмбэр аймаг
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
АБХС	Аймгийн Байгаль хамгаалах сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол Улсын Ерөнхий аудиторт Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

2. Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандартын талаарх мэдэгдэл

Аймгийн “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2014-2016 оны үйл ажиллагааны үр дүнд Гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч, дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулан АИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитад “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2014-2016 оны үйл ажиллагааны тайлан, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой анхан шатны баримтууд, мэдээ судалгаа, холбогдох ажилтнуудтай хийсэн ярилцлага, бусад материалуудыг хамрууллаа.

3. Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ аудитыг АДБОУС 3000, Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, холбогдох журмуудыг ашиглахаас гадна холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авч, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан, нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

4. Аудитын бүрэлдэхүүн

Аудитыг ГСА дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, ахлах аудитор Ц.Батсайхан гүйцэтгэлээ.

5. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл

Аудитын тайлан нь тайлангийн хураангуй, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, хавсралт гэсэн агуулгаар үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

6. Аудитад учирсан хүндрэл, бэрхшээл

Аудитын явцад “Тохижилт-Сүмбэр” ОНӨААТҮГ-ын нягтлан бодогч нь дуудсан хугацаанд ирээгүй, шаардлагатай мэдээ, судалгааг хугацаанд нь үнэн зөв гаргаж ирүүлээгүйгээс аудитын хугацаа хойшлогдож хүндрэл бэрхшээл учруулсан.

Бүлэг -1

Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, мэргэжлийн, чадварлаг боловсон хүчнээр хангагдах, чанартай ажил үйлчилгээ үзүүлэх шаардлагатай байна.

1.1 2014-2016 онд дэвшүүлсэн үйл ажиллагааны зорилго, зорилт нь тодорхойгүй байна.

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ нь байгууллагынхаа эрхэм зорилгыг “Цэвэр хот, хоггүй хотын төлөө” хэмээн тодорхойлсон байна. Эрхэм зорилгоо тодорхойлсон боловч жил бүр үйл ажиллагаагаа төлөвлөхдөө тодорхой зорилго, зорилт дэвшүүлэн ажиллаагүй байна.

Тус байгууллага нь Сүмбэр сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлэн сумын Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулан ажиллахаар зохион байгуулагдсан байна.

2014-2016 онд Сүмбэр сумын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ, гэрээ дүгнүүлсэн баримт материалыг аудитын явцад ирүүлээгүй тул байгууллагын үйл ажиллагааны зорилго, зорилтоо хэрхэн хэрэгжүүлж ажилласан нь тодорхойгүй байна.

Түүнчлэн 2014-2015 онд тус байгууллагын үйл ажиллагаанд аймгийн Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хяналт шалгалт хийгдээгүй байна. Үүнээс харахад тус байгууллага нь тодорхой зорилго зорилтгүй ажиллаж ирсэн бөгөөд зөвхөн орон нутгийн орлогод орлого төвлөрүүлэх төдийхнөөр үйл ажиллагаа нь хязгаарлагдаж, үйл ажиллагаанд нь гадаад болон дотоод хяналт шалгалт хийгдээгүй, урсгалаараа явж ирсэн байна.

Иймд хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд байгууллагын зорилго зорилтоо оновчтой тодорхойлж, эрх бүхий албан тушаалтантай үр дүнгийн гэрээ байгуулж, үйл ажиллагаагаа дүгнүүлэн ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.2 Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж чадаагүй байна.

“Тохижилт-Сүмбэр” ОНӨААТҮГ нь Сүмбэр сумын Засаг даргын 2002 оны 41 дүгээр захирамжаар үүсгэн байгуулагдсан байна.

Тус байгууллага нь Монгол Улсын татварын бүртгэлд аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын статустай, үйл ажиллагааны чиглэлээ ус хуримтлуулан ариутгах, түгээх үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн хэдий ч өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд ус түгээх, хог цэвэрлэх, ачих, авто замын арчилгаа, гудамжны гэрэлтүүлэг, цэцэрлэгжүүлэлт, нийтийн эзэмшлийн хөрөнгийн засвар, арчилгаа зэрэг ажил үүргийг хариуцан гүйцэтгэж байна.

Бүтэц зохион байгуулалтын хувьд аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нэртэй боловч тус байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого болох хог хаягдлын төлбөр хураамжийн орлого нь орон нутгийн орлогын дансанд 100 хувь төвлөрч, үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсвөөс бүрэн санхүүжүүлж

байгаагаас бие даан үйл ажиллагаа явуулж, орлогоороо зардлаа нөхөх санхүүгийн боломж, нөөц бололцоогоо дайчлах идэвхи чармайлт байхгүй байна.

Байгууллагын бүтэц тодорхойгүйгээс 2 төрлийн санхүүгийн тайлан гаргаж байгаа нь холбогдох хууль эрхийн актуудыг зөрчиж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлд “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ”, 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид “захирал” гэх/ томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараахь нөхцөлийг тусгана: 1/ энэ хуульд заасан эрх, үүрэг;2/ эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин;3/ техник, технологийг шинэчлэх даалгавар;4/ хамт олны хөдөлмөр хамгаалал, нийгмийн талаар авах арга хэмжээ;5/ менежментийн бодлого;6/ захирлаас болон үүргээ биелүүлэх талаар төрөөс хүлээх үүрэг;7/ удирдаж байгаа үйлдвэрийн газарт нь өмчлөгчөөс олгосон эд хөрөнгө, түүний хэмжээ;8/ цалин, нэмэгдэл хөлс, энэ хуульд заасан урамшуулал;9/ ажлын нөхцөл /унаа, холбоо зэрэг;10/ энэ хуульд заасан эд хөрөнгийн хариуцлага;11/ гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх журам, хугацаа;12/ хуульд харшлаагүй бусад нөхцөл” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 2014-2016 онд 27 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

“Тохижилт-Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2014-2016 оны төлөвлөсөн болон батлагдсан орон тоог хүснэгтээр харуулбал:

Д/д	Он	Төлөвлөсөн орон тоо	Батлагдсан орон тоо	Зөрүү
1	2014	33	27	6
2	2015	28	27	1
3	2016	28	27	1
Нийт дүн		89	81	8

Хүснэгтээс харахад: 2014-2016 онд орон тоог 28-33 байхаар төлөвлөсөн боловч жил бүр тогтмол 27 орон тоо батлагдсан байна.

2014-2016 онд үндсэн 27 орон тоотой ажилласан боловч гэрээгээр 3 ажилтан авч, нийт 30 орон тоотой ажилласан байна. Энэ нь сүүлийн жилүүдэд орон нутагт хөрөнгө оруулалтын ажлууд их хэмжээгээр хийгдсэнтэй холбоотой нийтийн эзэмшлийн зам талбай болон шинээр барьсан авто замууд ашиглалтад орж тус байгууллагын ажлын цар хүрээ нэмэгдсэн байна. Үүнтэй уялдуулан аймгийн Автозамын сангаас гэрээгээр ажиллуулж буй 3 ажилтны зардлыг санхүүжүүлж ирсэн байна.

Энэ нь байгууллагын орон тоог өнөөгийн бодит нөхцөл байдалтай уялдуулан оновчтой төлөвлөж, батлуулах шаардлагатай байгааг харуулж байна.

Иймд байгууллагын бүтэц, орон тоог оновчтой зохион байгуулж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.3 Үндсэн ажлын чиг үүрэгт хамааралтай ажил үйлчилгээг үзүүлэхэд мэргэжлийн, чадварлаг боловсон хүчин дутагдалтай байна.


“Тохижилт-Сүмбэр” ОНӨААТҮГ нь аймгийн хэмжээнд тохижилт үйлчилгээний бүхий л ажлыг хариуцан гүйцэтгэж байна. Хэдийгээр олон төрлийн ажил үйлчилгээ үзүүлэхээр ажлыг чиг үүрэгт нь тусгагдсан боловч мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр хангагдаагүй, төсөв хөрөнгө, хүний нөөцийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан чанартай үйлчилгээ үзүүлж чадахгүй байна.

Тухайлбал: Авто замын арчилгаа, гудамжны гэрэлтүүлэг, цэцэрлэгжүүлэлт зэрэг ажил үүргийг хийж гүйцэтгэхэд авозамын болон ногоон байгууламж хариуцсан мэргэжлийн ажилтан байхгүй, зөвхөн цэвэрлэгээ хийх, гэрлийн шилийг солих төдийхнөөр ажил үүрэг нь хязгаарлагдаж байна.

Гудамжны гэрэлтүүлэг, хотын доторхи засмал замын арчилгаа, тордолгоо, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн байгууламжуудын засвар үйлчилгээг ажилчид давхар хариуцан гүйцэтгэж байна.

Тус газар нь 2014-2016 онд 30 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна. Нийт ажиллагсдын 50 хувь нь эмэгтэй байна.

Ажиллагсдын боловсролын түвшинг диаграмаар харуулбал



Диаграмаас харахад: Нийт ажиллагсдын 17 хувь нь дээд, 10 хувь нь тусгай дунд, 23 хувь нь бүрэн дунд, 47 хувь нь бүрэн бус дунд, 3 хувь нь боловсролгүй байна.

Ажиллагсдын 73 хувь нь мэргэжил эзэмшээгүй, бүрэн дундаас доош боловсролтой иргэд ажиллаж байгаа нь тус байгууллагын үзүүлж буй ажил үйлчилгээ нь өнөөдрийн байдлаар ямар нэгэн нарийн мэргэжил шаардаагүй ажлын байрууд байгааг харуулж байна. Энэ нь тус байгууллага зөвхөн хог хаягдал ачиж буулгах, зөөврийн худгаар ус түгээх үйлчилгээг голлон гүйцэтгэж байгаатай холбоотой байна.


Ажлын байрны шаардлага нь тодорхой мэргэжил шаардаагүй, энгийн иргэд ажиллах боломжтой боловч ажиллах орчин нөхцөл хүнд, цалин хөлсний хангамж муу, илүү цагийн хөлс олгодоггүй зэргээс шалтгаалан ажиллах хүч тогтвор суурьшилтай ажилладаггүй, байнга солигдож байна. Тухайлбал: өвлийн улиралд

айл өрх, байгууллагуудын галлагаа эхэлж, ачаалал ихэсдэг бөгөөд ажлын шаардлагаар зайлшгүй илүү цагаар ажилладаг, дулааны улиралд хогны бохирдол их байхаас гадна барилга болон ахуйн хог хаягдал их гардаг зэрэг хүндрэл бэрхшээлтэй байна.

2014-2016 онд нийт 39 ажилтан ажилд орж, 38 хүн ажилтан ажлаас гарсан байна.

2016 оны байдлаар нийт 27 ажилтантай ажилласнаас дарга-1, нягтлан бодогч-1, нярав-1, зохион байгуулагч-1, байцаагч-2, хөдөлмөр хамгааллын инженер, цахилгаанчин-1, хог тээврийн жолооч-5, хог түрдэг ковш оператор-1, усны тэрэгний жолооч-1, хог ачигч-6, гүний худгийн усан санч-1, ус түгээгч-3, зам арчлагч талбайн үйлчлэгч-1, грашийн сахиул-1, төвлөрсөн хогийн цэгийн сахиул-1 байгаа бөгөөд үүнээс үндсэн ажил үйлчилгээний ажилтан 23 буюу 85 хувь нь байна.

2014-2016 оны батлагдсан орон тоог диаграмаар харуулбал



Диаграмаас харахад: 2014-2016 онд орон тоог нэмэгдүүлж батлаагүй бөгөөд орон тооны хязгаарт багтаан албан тушаалыг өөрчилж баталсан байна. Тухайлбал: 2015 онд өмнөх оноос байцаагч, хог тээврийн жолооч, ачигчийн орон тоог тус тус 1-ээр нэмэгдүүлж, усан санч, зам цэвэрлэгчийн орон тоог тус тус 2-оор бууруулан, цэцэрлэгчийн орон тоог хассан, 2016 онд өмнөх оноос усан санчийн орон тоог 1-ээр бууруулж, ачигчийн орон тоог 1-ээр нэмэгдүүлсэн байна.

Иймд хуулиар хүлээн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, чанартай ажил үйлчилгээ үзүүлэхийн тулд мэргэжлийн, чадварлаг боловсон хүчнээр хангагдах, орон тоогоо нэмэгдүүлэх асуудлыг зохистой түвшинд шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

1.4 Орлого нэмэгдүүлэх боломжийг судлаагүй, төсөвт 1 төгрөгийн орлого төвлөрүүлэхийн тулд төсвөөс 4.3 төгрөгийн зардал авсан байна.

Тус байгууллага нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх статустай боловч одоогийн нөхцөл байдалд үйл ажиллагааны зардлаа 100 хувь орон нутгийн төсвөөс санхүүжүүлж ирсэн байна. Энэ нь ажил үйлчилгээ үзүүлж буй хог хаягдлын үйлчилгээний хураамжийг орон нутгийн орлогод бүрэн төвлөрүүлж байгаатай

холбоотой боловч үндсэн чиг үүрэгт хамаарч буй бусад ажил үйлчилгээнээс орлого олох нөхцөл боломжийг судлаагүй, идэвх санаачлагатай ажиллаагүй байна.

Аудитын явцад тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайланд дараах 5 төрлийн санхүүгийн шинжилгээг хийж, нэгжид ногдох зардлын тооцоог гаргалаа. Үүнд:

1. **Төлбөрийн чадварын харьцаа:** Энэ нь байгууллагын төлбөрийн чадвар нь хүлээгдэж буй төлбөрийг цаг хугацаанд нь төлж барагдуулахад төлбөрийн хэрэгсэл хүрэлцэж буй эсэхээр тодорхойлно. Энэ харьцаагаар тус байгууллага нь ойрын хугацаанд өр төлбөрөө барагдуулах боломжгүй, өглөг авлагаасаа их, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна. Харин эргэлтийн хөрөнгө их хэмжээтэй байгаа учраас эргэлтийн хөрөнгө буюу авлага, бараа материалаасаа өрөө төлөх боломжтой гэсэн харьцаа гарсан.
2. **Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ:** Энэ нь үйл ажиллагаагаа өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх чадвартай байвал санхүүгийн хувьд тогтвортой байгааг харуулна. Энэ шинжилгээгээр тус байгууллага нь үйл ажиллагаагаа өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх чадвар их, нийт хөрөнгөнд эзлэх гадны хөрөнгийн оролцоо 0.03 хувь байгаа нь үйл ажиллагаа явуулах чадвартай байна.
3. **Хөрөнгө, капиталын ашиглалтын байдлын шинжилгээ:** Энэ нь санхүүгийн болон материал хөдөлмөрийн нөөцийг үр дүнтэй ашиглан эргэлтэнд оруулж ашиг орлогоо нэмэгдүүлж байгааг илэрхийлнэ. Энэ шинжилгээний үзүүлэлтүүд дунд гарсан.
4. **Хөрөнгө, капиталын ачаалалтын үзүүлэлтүүд:** Энэ нь борлуулалтын орлого олохдоо хөрөнгөө хэрхэн зөв зохистой ашиглаж байгааг харуулна. Энэ харьцаагаар үзүүлэлтүүд муу гарсан. Тус байгууллага нь борлуулалтын орлого олохдоо хөрөнгөө үр ашигтай ашиглаж чадахгүй байгаа, 1 төгрөгийн борлуулалт хийхийн тулд үндсэн хөрөнгөө ашиглаж чадахгүй байна.
5. **Ашигт ажиллагааны шинжилгээ:** Энэ шинжилгээгээр бүтээгдэхүүний ашиг олох чадвар, хөрөнгө капиталын ашигт ажиллагааг илэрхийлнэ. Тус байгууллага 2016 онд алдагдалтай ажилласан учраас энэ шинжилгээний үзүүлэлтүүд сөрөг буюу хасах утгатай гарсан.

2016 онд орон нутгийн орлогод 68,668.8 мянган төгрөгийг төвлөрүүлж, төсвөөс үйл ажиллагааны зардалд 298,050.3 мянган төгрөгийг санхүүжүүлсэн бөгөөд төсөвт 1 төгрөгийн орлого оруулсанаар төсвөөс 4.3 төгрөгийн зардал авсан байна.

Бүлэг 2

Үйл ажиллагааны үр ашгийг тооцсон зардлын төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй, орлого, зарлагыг дутуу бүртгэж тайлагнаснаар байгууллагын ашиг, алдагдлыг буруу илэрхийлж, жил бүр алдагдлын хэмжээ өссөөр байна.

2.1 Орлого бүрдүүлэх боломжит эх үүсвэрийн судалгаанд үндэслэн орлогын төлөвлөгөөг батлуулаагүй байна.

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ нь үндсэн үйл ажиллагааны орлогыг дараах орлогоос бүрдүүлж байна. Үүнд:

- Хог хаягдлын хураамжийн орлого
- Ундны ус худалдан борлуулсны орлого

Орлого бүрдүүлэхтэй холбоотой мөрдөгдөж буй эрх зүйн актыг авч үзвэл: ундны усыг худалдан борлуулах үнийг Сүмбэр сумын ИТХ-ын 2007 оны 37 дугаар тогтоолоор айл өрхөд 2 төгрөг 50 мөнгө, албан байгууллагад 5 төгрөгөөр, “Тохижилт-Сүмбэр” ОНӨААТҮГ-ын даргын 2014.09.01-ний өдрийн А/62 тоот тушаалаар гахайн аж ахуй, мал аж ахуйн газар, хүнсний ногоо болон мод усалгаанд 6 төгрөг, Барилга байгууламж, үйлдвэрлэл үйлчилгээнд төв худгаас нэг талдаа 3 км-ээс дотогш бол 8 төгрөг, 3 км-ээс их бол 10 төгрөг, хог хаягдал гаргасны төлбөрийг аймгийн ИТХ-ын 2010 оны 43 дугаар тогтоолоор айл өрх болон аж ахуйн нэгж тус бүрээр батлан гаргасан байна.

Хог хаягдлын хураамжийн орлогыг Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.17-д зааснаар орон нутгийн орлогод төвлөрүүлж байна. Харин ундны ус худалдан борлуулсны орлогыг өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэж, үйл ажиллагааны дансандаа төвлөрүүлэн зарцуулах боломжтой байна.

Сүмбэр сумын ИТХ-аас жил бүр орон нутгийн орлогын төлөвлөгөөг батлахдаа тус газраас орлого бүрдүүлэх боломжит тооцоо, судалгааг гаргуулан аваагүй, орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй батлаагүй байна. Тухайлбал: 2015 онд өмнөх оны төлөвлөгөөний дүнгээс 7,536.0 мянган төгрөг буюу 12.8 хувиар өсгөж төлөвлөсөн бол 2016 онд 1,750.0 мянган төгрөг буюу 2.6 хувиар бууруулж баталсан байна.

2014-2016 оны орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

Д/д	Он	Орлогын төлөвлөгөө			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувиар
1	2016	64,550.00	74,441.00	9,891.00	15.3
2	2015	66,300.00	66,731.30	431.3	0.7
3	2014	58,764.00	64,673.90	5,909.90	10.1
Нийт дүн		189,614.00	205,846.20	16,232.20	8.6

Хүснэгтээс харахад: 2014 онд орлогын төлөвлөгөө гүйцэтгэлээр 5,909.9 мянган төгрөг буюу 10.1 хувиар, 2015 онд 431.3 мянган төгрөг буюу 0.7 хувиар, 2016

онд 9,891.0 мянган төгрөг буюу 15.3 хувиар тус тус давж биелсэн нь орлогын төлөвлөлт үндэслэлгүй байгааг харуулж байна.

Тус байгууллага нь ундны усны орлогыг өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоор төлөвлөж батлуулах ёстой байтал уг орлогыг хог хаягдлын хураамжийн орлогод төвлөрүүлсэн нь орлого давж биелэхэд нөлөөлсөн байна.

Энэ нь Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т **“Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хувь хэмжээг нь тогтоож орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, эсхүл тухайн нутаг дэвсгэрт үйлчлэх дараахь татвар орон нутгийн татварт хамаарна”, 7.4.17-д “хог хаягдлын үйлчилгээний хураамж”** гэснийг зөрчсөн байна.

Өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогыг 2014 онд төлөвлөөгүй, 2015 онд 6,000.0 мянга, 2016 онд 2,000.0 мянган төгрөгийн орлогыг тус тус төлөвлөж батлуулсан байна.

Иймд үндсэн үйл ажиллагааны орлого болон орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр хуулиар тогтоосон орлогын төрөл, ангилалыг баримтлан бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөгөөгөө батлуулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.2 Ундны ус худалдан борлуулсны орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлсэнээс орлогын төлөвлөгөө давж биелсэн мэт харагдаж байна.

Тус байгууллага нь орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 2014 онд 58,764,0 мянга, 2015 онд 66,300.0 мянга, 2016 онд 64,550.0 мянган төгрөгөөр тус тус батлуулж, төлөвлөгөөг жил бүр давуулан биелүүлж ажилласан байна.

Орлогын төлөвлөгөөг жил бүр давуулан биелүүлж, төсөвт бүрэн төвлөрүүлсэн хэдий ч орлогын төвлөрүүлэлтэд хяналт тавьж ажиллаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс хуулиар тогтоогоогүй орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

Харин туслах үйл ажиллагааны орлогыг 2014 онд төлөвлөөгүй, 2015 онд 6,000.0 мянга, 2016 онд 2,000.0 мянган төгрөгөөр тус тус төлөвлөж батлуулсан боловч гүйцэтгэлээр 2015 онд орлого төвлөрүүлээгүй, 2016 онд 2,221,7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. 2015 онд орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй нь үндсэн үйл ажиллагааны орлого болох ундны усны орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

2014-2016 оны орлого бүрдүүлэлтийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

Д/д	Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Үүнээс усны орлого	ОНО-д төвлөрүүлэх цэвэр дүн	Төлөвлөгөө, цэвэр дүнгийн зөрүү
1	2016	64,550.0	74,441.0	8,553.0	65,888.0	-1,338.0
2	2015	66,300.0	66,731.3	9,539.7	57,191.6	9,108.4
3	2014	58,764.0	64,673.9	12,688.7	51,985.2	6,778.8
Нийт дүн		189,614.0	205,846.2	30,781.4	175,064.8	14,549.2

Хүснэгтээс харахад: Хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөөг жил бүр давуулан биелүүлсэн мэт харагдаж байгаа боловч усны орлогыг хассан цэвэр дүнгээр тооцож үзэхэд 2014 онд 6,778.8 мянга, 2015 онд 9,108.4 мянган төгрөгөөр тус тус орлого дутуу биелсэн байна. Харин 2016 онд хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөө 1,338.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 1,750.0 мянган төгрөг буюу 2.6 хувиар бууруулж баталсантай холбоотой байна.

2.3 Нягтлан бодох бүртгэлд орлогыг үнэн зөв тайлагнаагүй байна.

“Тохижилт-Сүмбэр” ОНӨААТҮГ нь үндсэн үйл ажиллагааны орлогыг 2014 онд 423,700.8 мянга, 2015 онд 385,972.7 мянга, 2016 онд 398,005.2 мянган төгрөгөөр тус тус бүртгэж, тайлагнасан байна. Орлогыг бүртгэж тайлагнахдаа санхүүгийн тайланд орлогын нэр төрлөөр нь ангилаагүй, санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлого, үндсэн үйл ажиллагааны орлого гэсэн 3 төрлөөр багцлан бүртгэсэн байна.

Орлогыг бөөн дүнгээр бүртгэж тайлагнаснаас орлогын эх үүсвэр тодорхойгүй, орлого бүрдүүлэлттэй холбоотой мэдээллийг тайлан хэрэглэгчдэд үнэн зөв мэдээлж чадахгүйд хүргэж байна.

Тус байгууллагын 2014-2016 оны санхүүгийн тайланд тусгагдсан орлогын судалгааг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№	Орлогын төрөл	2016 он			2015 он			2014 он		
		Санхүүгийн тайланд тусгах орлого	Тусгасан орлого	Зөрүү	Санхүүгийн тайланд тусгах орлого	Тусгасан орлого	Зөрүү	Санхүүгийн тайланд тусгах орлого	Тусгасан орлого	Зөрүү
1	Санхүүжилт	296,050.3	296,050.3	0.0	293,342.0	293,342.0	0.0	233,064.4	233,064.4	0.0
2	Хог хаягдлын орлого	65,887.9		65,887.9	57,191.6		57,191.6	51,985.3		51,985.3
3	Усны орлого	8,553.0		8,553.0	9,539.7		9,539.7	12,688.7		12,688.7
4	Хөрөнгө оруулалтын ажлын орлого			0.0			0.0	29,000.0		29,000.0
5	ХЭДС-гийн санхүүжилт	190.0		190.0	972.0		972.0	21,516.7		21,516.7
6	АБХС-гийн санхүүжилт	2,120.5		2,120.5			0.0	55,965.5		55,965.5
7	Авто замын санхүүжилт	28,753.8		28,753.8	25,350.7		25,350.7	18,408.9		18,408.9
8	Нэмэлт санхүүжилтийн орлого		31,064.3	-31,064.3		26,322.7	-26,322.7		126,234.9	-
9	Үндсэн үйл ажиллагааны орлого		70,890.6	-70,890.6		66,308.0	-66,308.0		64,401.5	-64,401.5
Нийт дүн		401,555.5	398,005.2	3,550.3	386,396.0	385,972.7	423.3	422,629.5	423,700.8	-1,071.3

Хүснэгтээс харахад: 2014 онд орлогыг 1,071.3 мянган төгрөгөөр илүү, 2015 онд 423.3 мянга, 2016 онд 3,550.3 мянган төгрөгөөр тус тус дутуу бүртгэж, тайлагнасан бөгөөд хог хаягдлын хураамжийн орлого болон ундны ус худалдан борлуулсаны орлогыг нягтлан бодох бүртгэл, ерөнхий журналд айл өрх, албан байгууллагаар нь нэг бүрчлэн бүртгээгүй, бөөн дүнгээр бүртгэсэн, кассад төвлөрүүлсэн орлогыг бэлнээр зарцуулсан боловч орлогыг бүртгэж тайлагнаагүйтэй холбоотой байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4.5-д “Бүх орлого, 14.4.6-д “Бүх зардал”-ыг заавал бүртгэнэ” гэснийг тус тус зөрчсөн байна.

Мөн тус газар 2014 онд 3 худаг, 2015 онд 3 худаг, 2016 онд 6 худгийг иргэдэд түрээслүүлэн ажилуулсан боловч усны орлого өмнөх оноос 2015 онд 3,419.0 мянга буюу 24.8 хувиар, 2016 онд 986.7 мянга буюу 10.3 хувиар тус тус буурсан нь Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолын 1.3-д “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээсээр эзэмшүүлэх зорилго нь төрийн өмчийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ” гэснийг зөрчсөн байна.

Хог хаягдал гаргасны хураамжийн орлогыг зөвхөн төлөгдсөн мөнгөн дүнгийн хэмжээгээр орлогоор бүртгэж, үлдэгдэл тооцоог авлага үүсгээгүй байна.

2014-2016 онд орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр орлогын бичилт хийгдсэн айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын орлогын судалгааг хүснэгтээр харуулбал:

/мян.төг /

Огноо	ААН,байгууллагууд				Айл өрх				Нийт төлөх	Нийт төлсөн	Нийт үлд
	тоо	төлөх	төлсөн	үлд	тоо	төлөх	төлсөн	үлд			
2016	158	32,109.5	30,452.6	1,656.9	2,433	34,050.0	31,955.3	2,094.7	66,159.5	62,407.9	3,751.6
2015	184	31,792.6	29,934.1	1,858.5	2,369	33,459.0	26,879.9	6,579.1	65,251.6	56,814.0	8,437.6
2014	162	30,960.6	28,645.1	2,315.5	2,369	31,200.0	25,181.9	6,018.1	62,160.6	53,827.0	8,333.6

Хүснэгтээс харахад: 2014 онд 8,333.6 мянга, 2015 онд 8,437.6 мянга, 2016 онд 3,751.6 мянган төгрөгийн орлогыг тайланд ондоо багтаан барагдуулж ажиллаагүй, санхүүгийн тайланд орлого болон авлагаар бүртгэж, тайлагнаагүй байна.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө” гэснийг зөрчсөн байна.

Хог хаягдлын хураамжийн орлогыг тайлант ондоо багтаан бүрэн төвлөрүүлээгүй, авлагын барагдуулалтад анхаарч, орлого олох талаар идэвхи санаачлагатай ажиллаагүй нь тус байгууллагын орлогын төлөвлөгөө жил бүр бага батлагддаг, орлогын төлөвлөгөөг усны орлогоор биелүүлдэг, үйл ажиллагааны зардлын санхүүжилтийг төсвөөс 100 хувь санхүүжүүлж байгаатай холбоотой байна.

Түүнчлэн орлогыг зөвхөн төрийн сангийн дансанд төвлөрүүлдэгээс иргэд гар дээрээ бэлэн мөнгөгүй тохиолдолд арилжааны банкны интернет болон мобайл банкиг ашиглан төлбөр хийх боломжгүй тул арилжааны банкинд “тэг” үлдэгдэлтэй орлогын данс нээлгэснээр орлогын бүрдүүлэлтэд сайнаар нөлөөлөх магадлалтай байна.

Иймд орлогын эх үүсвэрийг үнэн зөв ангилан бүртгэж, айл өрх, албан байгууллагаар нь нэг бүрчлэн данс бүртгэлд тусгах, дэвшилтэт техник, програм хангамжийг ашиглаж, бүртгэл тайлагналыг сайжруулах, арилжааны банкинд “тэг” үлдэгдэлтэй данс нээлгэх талаар холбогдох байгууллагад санал хүргүүлж шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.4 Орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлж, үйл ажиллагааны зардалд зарцуулах нөхцөл боломжийг алдсан байна.

Тус байгууллага нь Татварын хуулийн дагуу орон нутгийн орлогод зөвхөн хог хаягдал гаргасны хураамжийн орлогыг төвлөрүүлэх байтал 2014 онд 10,506.7 мянга, 2015 онд 9,493.9 мянга, 2016 онд мянга 5,654.0 мянга, нийт 25,654.6 мянган төгрөгийн усны орлогыг төвлөрүүлж, өөрийн үндсэн үйл ажиллагаанаас орлого олж, үйл ажиллагааны зардалдаа зарцуулах боломжийг алдсан байна.

Орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор 2014 онд Сүмбэр сумын ОНХС-гаас 29,000.0 мянга, аймгийн Байгаль хамгаалах сангаас 40,729.9 мянга, 2015 онд аймгийн Автозамын сангаас 4,900.0 мянга, нийт 74,629.9 мянган төгрөгийн ажлуудыг хийж гүйцэтгэн нэмэлт орлого олсон боловч 2016 онд орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх ажил хийгдээгүй байна.

Хуулийн дагуу орон нутгийн орлогод төвлөрүүлэх хог хаягдлын хураамжийн орлогоос гадна өөрийн нөөц бололцоогоо дайчлан орлого олох боломжтой үндсэн хөрөнгүүдийг түрээслүүлэх, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй өөрийн чиг үүрэгт хамаарах ажлуудын тендер шалгаруулалтад оролцох, олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллагуудад төсөл бичих зэргээр орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх талаар тодорхой санал санаачилга гарган ажиллаагүй байна.

Тус газарт бүртгэлтэй аж ахуй нэгж, байгууллага болон айл өрхийн судалгааг аймгийн Татварын хэлтэс болон Статистикийн хэлтсийн судалгаатай харьцуулж хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

Огноо	ААН,байгууллагууд			Айл өрх		
	Аймгийн Татварын хэлтэст бүртгэлтэй	Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-т бүртгэлтэй	Зөрүү	Аймгийн Статистикийн хэлтэст бүртгэлтэй	Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-т бүртгэлтэй	Зөрүү
2016	409	158	251	3,048	2,433	615
2015	369	184	185	2,972	2,369	603
2014	334	162	172	2,823	2,369	454
Нийт дүн	1,112	504	608	8,843	7,171	1,672

Хүснэгтээс харахад: Тус газарт бүртгэлтэй ААНБ-ын тоо нь аймгийн Татварын хэлтсийн тоо мэдээнээс 608, айл өрхийн тоо нь Статистикийн хэлтсийн тоо мэдээнээс 1,672-оор тус тус бага байна. Энэ нь хог хаягдлын хураамжийг ААНБ болон айл өрхөд бүрэн ногдуулдаггүй мэт харагдаж байгаа бөгөөд аймгийн Татварын хэлтэс болон Статистикийн хэлтэстэй тоон мэдээгээ нэгтгэн тулгаж баталгаажуулдаггүй бөгөөд дээрх бүртгэлтэй ААНБ, айл өрхийн тоо нь тус байгууллагад бүртгэлтэй ААНБ, айл өрхийн тооноос ямар шалтгаанаар зөрүүтэй байгаад дүн шинжилгээ хийгээгүй, нэгдсэн судалгаа мэдээллийн санг бүрдүүлээгүй байна.

Иймд холбогдох байгууллагуудын бүртгэл, судалгааны дүнг өөрийн байгууллагын тоо мэдээтэй тулган баталгаажуулж, ААНБ, айл өрхийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, хог хаягдал гаргасны төлбөрөөс чөлөөлөгдөж байгаа ААНБ, айл өрхийн мэдээллийг тодорхой болгох, шаардлагатай нотлох баримтанд тулгуурлан өөрчлөлт шинэчлэлтийг тухай бүр хийж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.5 Үйл ажиллагааны үр ашгийг тооцсон зардлын төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй байна.

Тус газар нь 2014-2016 онд үйл ажиллагааны үр ашгийг тооцсон зардлын төлөвлөгөө батлуулж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.3-д “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэснийг зөрчсөн байна.

Орон нутгийн төсвөөс үйл ажиллагааны зардлаа 100 хувь санхүүжүүлж байгаатай холбогдуулан жил бүр төсвийн байгууллагын чиг үүргийн дагуу төсвийн төсөл боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

2014-2016 онд боловсруулсан төсвийн төсөл, батлагдсан төсвийн судалгааг хүснэгтээр харуулбал:

№	Зардлын нэр	2016			2015			2014		
		Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Зөрүү	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Зөрүү	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Зөрүү
1	Цалин болон НДШ-ийн зардалд	236,905.6	189,307.7	47,597.9	191,024.6	205,968.0	-14,943.4	160,818.1	150,579.4	10,238.7
2	Тогтмол зардалд	8,866.1	27,020.0	-18,153.9	7,095.9	5,970.0	1,125.9	7,565.2	6,161.8	1,403.4
3	Хангамжийн материалын зардалд	9,325.1	2,959.1	6,282.0	6,550.3	3,196.0	3,354.3	7,005.2	8,025.4	-1,020.2
4	Нормын хувцас зөөлөн эдлэл худалдан авах зардал	21,722.8	2,800.0	18,922.8	10,900.0	10,700.0	200.0	9,554.2	3,500.0	6,054.2
5	Урсгал засварын зардал	9,200.0	1,565.8	7,634.2	74,906.2	4,800.0	70,106.2	13,656.2	4,000.0	9,656.2
6	Гудамжны гэрэлтүүлгийн зардал	34,559.2	7,700.0	26,859.2	25,944.2	22,100.0	3,844.2	21,556.6	15,210.9	6,345.7
7	Хог хаягдал устгах, ариутгах, ариутгал цэвэрлэгээ	72,722.4	51,230.2	21,492.2	43,489.4	39,031.0	4,458.4	38,975.0	38,975.0	0.0
8	Хөрөнгийн зардалд	1,602.0	12,000.0	-10,398.0	0.0	0.0	0.0	750.0	3,270.0	-2,520.0
9	Төлбөр хураамж бусад зардал	2,897.0	2,467.5	329.5	2,458.0	2,002.0	456.0	2,743.9	2,341.9	402.0
10	Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд	3,975.0	1,000.0	1,500.0	0.0	1,000.0	-1,000.0	1,200.0	1,000.0	200.0
Нийт дүн		401,775.2	298,050.3	102,065.9	362,368.6	294,767.0	67,601.6	263,824.4	233,064.4	30,760.0

Хүснэгтээс харахад: 2014-2016 онд боловсруулсан төсвийн төслийг саналыг 30,760.0-102,065.9 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна. Төсвийн төслийн саналыг жил бүр нийт дүнгээр нь бууруулан баталсан боловч зарим зардлыг нэмэгдүүлж баталсан байна.

Тухайлбал:

- 2014 онд хангамжийн материалын зардлыг 1,020.2 мянга, хөрөнгийн зардлыг 2,520.0 мянган төгрөгөөр,
- 2015 онд цалингийн зардлыг 14,943.4 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 1,000.0 мянган төгрөгөөр,
- 2016 онд тогтмол зардлыг 18,153.9 мянга, хөрөнгийн зардлыг 10,398.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

Байгууллагын төсөв их хэмжээгээр хасагдаж, зарим зардлын зүйл ангийг нэмэгдүүлэн баталж байгаа нь зардлын суурь судалгааг бодитой тооцож, зардлыг нэр төрлөөр нь үндэслэлтэй төлөвлөөгүйг харуулж байна.

Иймд байгууллагын зардал, үр ашгийн тооцооллыг төсвийн байгууллын чиг үүргийн хүрээнд хязгаарлагдмал байдлаар биш аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын чиг үүрэгт хамааралтайгаар тооцож, үйл ажиллагааны үр ашгийг эдийн засгийн тооцоо судалгаанд үндэслэн үйл ажиллагаагаа өргөжүүлэх нөхцөл боломжийг эрэлхийлж ажиллах шаардлагатай байна.

2.6 Бүтээгдэхүүний өртгийг тооцож ажиллаагүй байна.

Тус газар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэсэн өмчийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа боловч төсвийн байгууллагын хэлбэрээр үйл ажиллагаагаа тайлагнаж ирсэн тул борлуулсан бүтээгдэхүүний өртгийг тооцоогүй, зөвхөн төсвөөс олгосон зардлын гүйцэтгэлийг тайлагнасан байна.

Энэ нь үйл ажиллагааны зардлыг 100 хувь төсвөөс санхүүжүүлсэнээс тус байгууллагын аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэсэн өмчийн хэлбэр нь алдагдаж төсвийн байгууллага ч биш, аж ахуйн газар ч биш холимог хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

2.7 Үндсэн үйл ажиллагааны орлогыг бэлнээр зарцуулсан байна.

“Тохижилт-Сүмбэр” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд зардалд 2014 онд 233,064.4 мянга, 2015 онд 294,767.0 мянга, 2016 онд 298,050.3 мянган төгрөг тус тус батлагдаж, гүйцэтгэлээр 2014 онд 232,895.7 мянга, 2015 онд 293,291.6 мянга, 2016 онд 297,443.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2014-2016 оны батлагдсан төсөв нийт дүнгээрээ хэтрээгүй боловч төсвийг зардлын бүлэг дотор гүйлгэн зарцуулсан байна.

Төсвийн зардлыг зардлын зүйл ангиар харьцуулсан судалгааг дараах хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Төсвийн гүйцэтгэл		Зөрүү
	2015 он	2016 он	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	293,291.6	297,443.5	-4,151.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,539.0	167,586.0	13,953.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,356.9	21,349.7	2,007.2
Тогтмол зардал	5,970.0	27,019.0	-21,049.0
Хангамж, бараа материалын зардал	42,097.8	54,017.3	-11,919.5
Нормативт зардал	10,669.9	2,799.9	7,870.0
Эд хогшил худалдан авах	4,787.1	13,565.7	-8,778.6
Дотоод албан томилолт	128.0	160.0	-32.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,926.5	2,245.9	-319.4
Бараа үйлчилгээний бусад зардал	22,102.0	7,700.0	14,402.0
Урсгал шилжүүлэг	714.4	1,000.0	-285.6

/мян.төг/

Хүснэгтээс харахад: 2016 онд зардлын гүйцэтгэл өмнөх оныхоос нийт 4,151.9 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар өссөн байна. Тухайлбал:

- Цалингийн болон НДШ-ийн зардал нь өмнөх оноос 15,960.2 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь 2016 онд орон тоонд өөрчлөлт ороогүй боловч өмнөх оноос цалин болон НДШ-ийн зардлын дүнг 16,681.3 мянган төгрөгөөр хасаж баталсан нь нөлөөлсөн байна.

- Тогтмол зардал өмнөх оноос 21,049.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 2016 оны төсвийн хуваарьт гудамжны гэрэлтүүлгийн зардал 20,227.5 мянган төгрөгийг гэрэл цахилгааны зардалд баталж зарцуулсантай холбоотой байна.
- Хангамж, бараа материалын зардал өмнөх оноос 11,919.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тээвэр шатахууны зардлыг нэмэгдүүлж баталсантай холбоотой байна.
- 2016 онд нормативт зардлыг өмнөх оноос 7,870.0 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.
- Эд хогшил худалдан авах зардал нь өмнөх оноос 8,778.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тус газарт 2016 онд олгогдсон усны татаасын зардлаас 12,000.0 мянган төгрөгөөр хөрөнгө худалдаж авсан нь нөлөөлсөн байна.

Аудитын явцад үндсэн үйл ажиллагааны орлогыг төсөвт төвлөрүүлсэн байдлыг тулган баталгаажуулахад: Ус борлуулсан болон хог хаягдал гаргасны хураамжийг кассад бэлнээр хураан авсанаас 2014 онд 639,8 мянга, 2015 онд 113.0 мянга, 2016 онд 3,219.5 мянга, нийт 3,972.3 мянган төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэлгүйгээр батлагдсан төсвөөс гадуур бэлнээр зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д "Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын I хавсралтаар баталсан төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.6-д "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд холбогдох хууль тогтоомж, журмыг зөрчсөн тул 639.8 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2.8 Үйл ажиллагааны зардлыг үнэн зөв, бүртгэж тайлагнаагүй байна.

"Тохижилт-Сүмбэр" ОНӨААТҮГ нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 2014 онд 485,645.3 мянга, 2015 онд 719,208.8 мянга, 2016 онд 819,338.4 мянган төгрөгөөр тус тус бүртгэж, тайлагнасан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг кассад бэлнээр хураан авч төсөвт төвлөрүүлдэг бөгөөд 2014-2016 онд нийт 3,972.3 мянган төгрөгийг санхүүгийн тайланд бүртгэж тайлагнаагүй, бараа материалын тодруулга тайланд бараа материалын зардлыг 2014 онд 1,522.5 мянга, 2015 онд 9,866.1 мянга, 2016 онд 2,700.0 мянган төгрөгөөр тус тус дутуу, 2014 онд 2,109.2 мянга, 2016 онд 36.0 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн байна.


Мөн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг үнэн зөв тооцож бүртгээгүйгээс 2015 онд 177,683.5 мянга, 2016 онд 55,828.4 мянган төгрөгөөр тус тус дутуу тооцсон байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4.6-д "Бүх зардал"-ыг заавал бүртгэнэ", Аж ахуй нэгжийн орлогын албан татварын хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-д "Үндсэн хөрөнгийг дор дурдсан хугацаагаар ашиглахаар тооцож, түүний элэгдэл,

хорогдлын шимтгэлийг шулуун шугамын аргаар дараах байдлаар байгуулна” гэснийг тус тус зөрчсөн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 2014-2016 онд нийт 182,278.4 мянган төгрөгийн хүлээн авч зарцуулсан бөгөөд зардлыг бүртгэж тайлагнасан байна

Тус газар нь 2014 онд авлага 108.9 мянга, өглөг 3,599.1 мянга, 2015 онд авлага 2,209.7 мянга, өглөг 14,022.1 мянга, 2016 онд авлага 796.1 мянга, өглөг 1,859.0 мянган төгрөгийн үлдэгдлийг тус тус санхүүгийн тайланд тусгасан байна.



Диаграмаас харахад: 2015 онд авлага өмнөх оноос 2,100.8 мянган төгрөгөөр буюу 19.2 дахин, 10,423.0 мянган төгрөгөөр буюу 2.9 дахин тус тус нэмэгдсэн бол 2016 онд авлага өмнөх оноос 1,413.6 мянган төгрөгөөр буюу 1.7 дахин, өглөг өмнөх оноос 12,163.1 мянган төгрөгөөр буюу 6.5 дахин тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэснийг мөрдөж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.9 Жил бүр үйл ажиллагааны алдагдлын хэмжээ өссөөр байна.

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ нь үйл ажиллагааны зардлаа 100 хувь орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байна. 2014-2016 оны байдлаар тус байгууллага нь 10,200.2-367,090.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Тус байгууллага нь 2014 онд нийт 2,205,862.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй бөгөөд үүнээс 1,712,250.2 төгрөг буюу 77.6 хувийг нийтийн эзэмшлийн хөрөнгө эзэлж байна. Нийтийн эзэмшлийн хөрөнгө 77.6 хувийг эзэлж байгаатай холбоотойгоор элэгдлийн зардал их хэмжээгээр өсөж байгууллага алдагдалтай ажиллахад хүргэж байна.

Аймаг, орон нутагт хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг эзэнжүүлэх зорилгоор тус байгууллагын үйл ажиллагаатай хамааралгүй, тухайн байгууллагад нь бүртгүүлж болох зарим хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгуулсан байна.

Дээрх байдлаас харахад байгууллага ашигтай ажиллах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, ашиглалтгүй болон байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгүүдийг шилжүүлэх талаар холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтанд санал хүсэлт гаргаагүй, урсгалаараа явж ирсэн байна.

Нөгөө талаас Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн алба болон аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс тус байгууллагын үйл ажиллагаа, хөрөнгийн талаар анхаарч ажиллаагүй, байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж буй хүчийн зүйлийг судлаагүй, зөвхөн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлыг эзэнжүүлэх зорилгоор хөрөнгүүдийг данс бүртгэлд нь тусгуулж ирсэн, хөрөнгө оруулалтын ажлуудын чанар байдалд хяналт хийж, чанарын шаардлага хангасан хөрөнгүүдийг хүлээлгэн өгдөггүй, мөн орлого олох боломжид тулгуурлан орлогын төлөвлөгөөг батлаагүйгээс зардлаа 100 хувь төсвөөс санхүүжүүлж ирсэн байна.

Тус газар нь орлогын тайланд 2015 онд 4,219,507.0 мянга, 2016 онд 319,301.6 мянга, нийт 4,538,808.6 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг орлогоор бүртгээгүй, элэгдлийн зардлыг тусгаагүй, үндсэн үйл ажиллагааны орлогыг 587.7 мянган төгрөгөөр дутуу тусгасан байна.

Энэ нь Аж ахуй нэгжийн орлогын албан татварын хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-д "Үндсэн хөрөнгийг дор дурдсан хугацаагаар ашиглахаар тооцож, түүний элэгдэл, хорогдлын шимтгэлийг шулуун шугамын аргаар дараахь байдлаар байгуулна" гэснийг зөрчсөн байна. Орлого, зарлагыг дутуу бүртгэж тайлагнаснаар байгууллагын ашиг, алдагдал үнэн зөв тооцогдохгүй байна.

Иймд тус байгууллагын үйл ажиллагаатай хамааралгүй, зардал их хэмжээгээр өсгөж, алдагдалтай ажиллахад нөлөөлж байна үндсэн хөрөнгүүдийг харьяалагдах байгууллагуудад нь шилжүүлэх, шаардлага хангахгүй үндсэн хөрөнгүүдийг данснаас хасах асуудлыг холбогдох байгууллагад санал хүргүүлж шийдвэрлүүлэх, орлого, зарлагыг үнэн зөв бүртгэж, байгууллагын үйл ажиллагааны ашиг, алдагдлыг үнэн зөв тооцох зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, хөрөнгийн элэгдлийг хууль тогтоомжийн дагуу үнэн зөв тооцсон эсэх

Бүлэг 3

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, хөрөнгийн элэгдлийн зардлыг үнэн зөв тооцож, ажлын байрны нөхцлийг сайжруулах шаардлагатай байна.

3.1 НББОУС-д нийцүүлэн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, элэгдэл байгуулах хувь хэмжээг тогтоогоогүй байна.

"Тохижилт-Сүмбэр" ОНӨААТҮГ нь 2016 оны жилийн эцсийн байдлаар 61,472.8 мянган төгрөгийн бараа материал, 7,035,863.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэж тайлагнасан байна.

2016 оны жилийн эцсийн байдлаар нийт үндсэн хөрөнгийн 0.67 хувь буюу 47,168.8 мянган төгрөгийн хөрөнгө анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн хөрөнгө ашиглагдаж байгаа бөгөөд ашиглалтын хугацаа дууссан, дансны үнэ нь тэг өртөгтэй хөрөнгүүдийг цэгцлэх шаардлагатай байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 болон 20.2.3 дахь заалтуудыг тус тус зөрчиж байгаа тул дээрх үндсэн хөрөнгүүдийг данснаас хасах, эсхүл цаашид ашиглах боломжтой гэж үзсэн тохиолдолд хөрөнгийн ашиглах

хугацаа, үнэлгээг тогтоох талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг 2014 оны 7-р сараас эхлэн НББ-ийн програм хангамжаар гүйцэтгэсэн бөгөөд үндсэн хөрөнгийг програмд бүртгэхдээ зарим хөрөнгийн ашиглалтын хугацааг оруулаагүйгээс 117,608.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал дутуу тооцож, 2015 онд нөхөн тооцсон байна.

Тус байгууллага нь 2010 онд НБББББ-ийг боловсруулан баталсан бөгөөд уг баримт бичигт үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг 5 нэр төрлийн хөрөнгөнд тооцохоор тогтоосон нь холбогдох хууль эрхийн актууд, заавар журамтай нийцээгүй байна.

Иймд НБББББ-ийг өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэн боловсруулж, үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, элэгдэл байгуулах хувь хэмжээг тогтоож, НББОУС-ыг мөрдлөг болгон ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв

3.2 Үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, ашиглалтын шаардлага хангахгүй ажлын байранд үйл ажиллагаагаа явуулж байна.

Аудитын явцад тус байгууллагын хөрөнгөнд хэсэгчилсэн тооллого хийж, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалттай танилцахад дараах байдалтай байна. Үүнд:

1. Байгууллагын дансанд бүртгэлтэй 4 төрлийн 43,220.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл эвдэрсэн, 1,514.8 мянган төгрөгийн бага оврын трактор, 7,080.0 мянган төгрөгийн 6 ширхэг усны сав, нийт 51,814.8 мянган төгрөгийн хөрөнгүүд үндсэн үйл ажиллагаанд ашиглагдахгүй байна.
2. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн нийтийн эзэмшлийн хөрөнгүүдийг тус байгууллагад хариуцуулж, данс бүртгэлд тусгуулсан боловч ашиглалтын зардлыг төсөвт нь баталж өгөөгүйгээс нийт 169,802.0 мянган төгрөгийн хөрөнгө эвдэрч, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулсан байна. /Хавсралт- № 1/
3. Байгууллагын үйл ажиллагаатай хамааралгүй 43,942.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгуулсан байна. /Хавсралт-№ 2 /
4. Хөрөнгө нь биетээр бодитой оршин байхгүй таксины зогсоол 990.0 мянга, төвлөрсөн хогийн цэг 79,041.8 мянга, нийт 80,031.8 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж, элэгдэл тооцсон байна.
5. Үндсэн хөрөнгийн шинж чанартай 40,990.5 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна. /Хавсралт-№ 3 /

Эдгээр зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т “Төрийн байгууллага, албан газар нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараахь эрх, үүрэгтэй: 1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах” гэснийг зөрчсөн байна.

Иймд Үндсэн хөрөнгийн шинж чанартай 40,990.5 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалаас үндсэн хөрөнгөнд бүртгүүлэх албан шаардлага өгч, байгууллагын хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, эвдэрч хэмхэрсэн

хөрөнгийг засаж сэлбэн үйл ажиллагааны эргэлтэнд оруулах, засвар үйлчилгээ авах боломжгүй эвдрэл гэмтэлтэй, биетээр оршин байхгүй, байгууллагын үйл ажиллагаатай хамааралгүй, зардал их хэмжээгээр өсгөж, алдагдалтай ажиллахад нөлөөлж байгаа зарим үндсэн хөрөнгүүдийг харьяалагдах байгууллагуудад нь шилжүүлэх асуудлыг холбогдох байгууллагад санал хүргүүлж шийдвэрлүүлэх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Тус байгууллагын үйл ажиллагаа явуулж буй албан ажлын байр нь стандартын шаардлага хангаагүй, аймгийн Мэргэжлийн хяналтын газраас шаардлага хангахгүй байгаа талаар дүгнэлт гарсан, албан ажлын зориулалтаар баригдаагүй, хуучин гражийн зориулалттай барилгыг аж ахуйн аргаар өөрсдийн нөөц бололцоог ашиглан засварлан үйл ажиллагаагаа явуулж байгаа нь ажиллагсдын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангагдахгүй байгаа төдийгүй байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдаагүйгээс хувийн эд хөрөнгөө ашиглаж байна. Тухайлбал: байгууллагын удирдлага өөрийн ширээ сандал, нягтлан бодогч зөөврийн компьютер, сейф зэргийг ашиглаж байна

Иймд ажиллагсдын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангагдахгүй байгаад анхаарч, стандартын шаардлага хангасан ажлын байртай болох шаардлагатай тавилга, техник хэрэгслээр хангах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд санал хүсэлт гаргаж, ажлын байрны нөхцлийг сайжруулах шаардлагатай байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт оновчтой зохион байгуулагдсан эсэх

Бүлэг 4

Дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлээгүй, Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.1 Дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Байгууллагын даргын 2014.09.01-ний өдрийн Б/61а тоот тушаалаар дотоод хяналтын ажилтнаар тус байгууллагын зохион байгуулагч П.Нарандэлгэрийг томилсон боловч 2014-2016 онд дотоод хяналт шалгалт хийсэн ажлын тайлан холбогдох баримт бичгийг 2 ажилтан ажил хүлээлцэхэд алга болсон гэсэн шалтгаанаар аудитын хугацаанд гаргаж ирүүлээгүй, байгууллагын даргын тушаалаар дотоод хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөө батлагдаагүй зэргээс харахад тус байгууллага нь дотоод хяналтыг үр дүнтэй зохион байгуулж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д. “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд дотоод хяналт шалгалт хийх дүрэм журмаа баталж, дотоод хяналтын ажилтанг томилон ажиллуулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

4.2 Хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 36.6 хувьтай байна.

Тус газрын 2014-2016 оны санхүүгийн тайланд Голден пейж аудит ХХК санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудит хийж зөвлөмж, албан шаардлага өгсөн боловч 2015 онд 60 хувьтай хэрэгжүүлж, 2016 онд хэрэгжүүлж ажиллаагүй, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2014-2015 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 9 зөвлөмж өгсөн боловч 55 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Үүнээс харахад тус байгууллага нь хяналт шалгалтын байгууллагуудаас хийсэн шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулаагүй, зөрчил дутагдлыг арилгах талаар идэвхи санаачлагатай ажиллаагүй байна.

4.3 Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "...дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна", 3.1.1-д "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд" гэсэн заалтын үйлчлэх хүрээнд тус байгууллага хамаарч байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллүүдийг дутуу оруулсан байна. Тухайлбал: 2015-2016 онд байгууллагын батлагдсан төсвийг бүтэн жилээр, 2016 оны 12-р сард хөрөнгө болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг оруулаагүй, байгууллагын удирдлага 2016.09.16-ны өдрөөс шинэчлэгдэн томилогдсон боловч удирдлагын мэдээллийг өөрчлөөгүй байна.

Иймд Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн оруулж хэвших шаардлагатай бөгөөд мэдээллийг олон удаа хугацаа хоцроож, дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т "Шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөн төсвийн байгууллагын албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан түүнийг томилсон эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулна" гэсний дагуу хариуцлага тооцуулах үндэслэл болохыг анхаарч ажиллахыг зөвлөж байна.

Аудитаар нийт 432,355.4 мянган төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлснээс 639.8 мянган төгрөгийн төлбөрийн акт бичиж, 40,990.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 390,725.1 мянган төгрөгийн зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-1

- Байгууллагын бүтэц, зохион байгуулалт тодорхой бус, зорилго зорилтоо оновчтой тодорхойлоогүй, эрх бүхий албан тушаалтантай үр дүнгийн гэрээ байгуулж, үйл ажиллагаагаа дүгнүүлэн ажиллаагүй, байгууллагын бүтэц тодорхойгүйгээс 2 төрлийн санхүүгийн тайлан гаргаж, холбогдох хууль эрхийн актуудыг зөрчсөн байна.
- Үндсэн ажлын чиг үүрэгт хамааралтай ажил үйлчилгээг үзүүлэхэд мэргэжлийн, чадварлаг боловсон хүчин дутагдалтай, төсөв хөрөнгө, хүний нөөцийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан чанартай үйлчилгээ үзүүлж чадахгүй байна.
- Үйл ажиллагааны зардлаа 100 хувь орон нутгийн төсвөөс санхүүжүүлж ирсэн, үндсэн чиг үүрэгт хамаарч буй бусад ажил үйлчилгээнээс орлого олох нөхцөл боломжийг судлаагүй, идэвх санаачлагатай ажиллаагүй, төсөвт 1 төгрөгийн орлого төвлөрүүлэхийн тулд төсвөөс 4.3 төгрөгийн зардал авсан байна.

Бүлэг-2

- Орлого бүрдүүлэх боломжит эх үүсвэрийн судалгаанд үндэслэн орлогын төлөвлөгөөг батлуулаагүй, үйл ажиллагааны үр ашгийг тооцсон зардлын төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.
- Орлогын төлөвлөгөөг жил бүр давуулан биелүүлж, төсөвт бүрэн төвлөрүүлсэн хэдий ч хуулиар тогтоогоогүй орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлсэнээс орлого давж биелэхэд нөлөөлсөн байна.
- Ажил, үйлчилгээ үзүүлж буй ААНБ, айл өрхийн нэгдсэн судалгаа, мэдээллийн санг бүрдүүлээгүйгээс хог хаягдлын хураамжийг бүрэн ногдуулдаггүй, орлогыг тайлант ондоо багтаан бүрэн төвлөрүүлээгүй, авлагаар бүртгэж тайлагнаагүй байна.
- Нягтлан бодох бүртгэлд үйл ажиллагааны орлого, зарлагыг үнэн зөв бүртгээгүй, үндсэн үйл ажиллагааны орлогыг бэлнээр зарцуулсан байна.
- Байгууллагын үйл ажиллагааны зардлыг 100 хувь төсвөөс санхүүжүүлж ирсэнээс байгууллага ашигтай ажиллах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, ашиглалтгүй болон байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгүүдийг эзэмшиж элэгдлийн зардлыг тооцсоноос жил бүр алдагдлын хэмжээ өссөөр байна.

Бүлэг-3

- Үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, хөрөнгийн ашиглалтын хугацаа, элэгдлийн зардлыг үнэн зөв тооцоогүй, стандартын шаардлага хангахгүй ажлын байранд үйл ажиллагаагаа явуулж байна

Бүлэг-4

- Дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлээгүй, шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Хяналт шалгалтын байгууллагуудаас хийсэн шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулаагүй, зөрчил дутагдлыг арилгах талаар идэвхи санаачлагатай ажиллаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

“Тохижилт-Сүмбэр” ОНӨААТҮГ-ын захиралд:

1. Байгууллагын бүтэц, орон тоог оновчтой зохион байгуулж, зорилго зорилтоо тодорхойлох, эрх бүхий албан тушаалтантай үр дүнгийн гэрээ байгуулж, үйл ажиллагаагаа дүгнүүлэн ажиллах
2. Хуулиар хүлээн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, чанартай ажил үйлчилгээ үзүүлэхийн тулд мэргэжлийн, чадварлаг боловсон хүчнээр хангагдах, орон тоогоо нэмэгдүүлэх асуудлыг зохистой түвшинд шийдвэрлүүлэх
3. Үндсэн үйл ажиллагааны орлого болон орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр хуулиар тогтоосон орлогын төрөл, ангилалыг баримтлан бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөгөөгөө батлуулах
4. ААНБ, айл өрхийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, орлогын эх үүсвэрийг үнэн зөв ангилан бүртгэж, дэвшилтэт техник, програм хангамжийг ашиглах
5. Байгууллагын зардал, үр ашгийн тооцооллыг төсвийн байгууллын чиг үүргийн хүрээнд хязгаарлагдмал байдлаар биш аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын чиг үүрэгт хамааралтайгаар тооцож, эдийн засгийн тооцоо судалгаанд үндэслэн үйл ажиллагаагаа өргөжүүлэх нөхцөл боломжийг эрэлхийлж ажиллах
6. Хог хаягдлын хураамжийн орлогын төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх нөхцөл боломжийн хүрээнд арилжааны банкинд “тэг” үлдэгдэлтэй данс нээлгэх талаар холбогдох байгууллагад санал хүргүүлж шийдвэрлүүлэх
7. НБББББ-ийг өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэн боловсруулж, үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, элэгдэл байгуулах хувь хэмжээг тогтоож, НББОУС-ыг мөрдлөг болгон ажиллах
8. Байгууллагын хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, эвдэрч хэмхэрсэн хөрөнгийг засаж сэлбэн үйл ажиллагааны эргэлтэнд оруулах, засвар үйлчилгээ авах боломжгүй эвдрэл гэмтэлтэй, биетээр оршин байхгүй, байгууллагын үйл ажиллагаатай хамааралгүй, зардал их хэмжээгээр өсгөж, алдагдалтай ажиллахад нөлөөлж байгаа зарим үндсэн хөрөнгүүдийг харьяалагдах байгууллагуудад нь шилжүүлэх асуудлыг холбогдох байгууллагад санал хүргүүлж шийдвэрлүүлэх
9. Ажиллагсдын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангагдахгүй байгаад анхаарч, стандартын шаардлага хангасан ажлын байртай болох шаардлагатай тавилга, техник хэрэгслээр хангах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд санал хүсэлт гаргаж, ажлын байрны нөхцлийг сайжруулах
10. Дотоод хяналт шалгалт хийх дүрэм журмаа баталж, дотоод хяналтын ажилтанг томилон ажиллуулах
11. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

“ТОХИЖИЛТ СҮМБЭР”
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖАХУЙН ТООЦООТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
Говьсүмбэр аймаг, Чойр хот
Утас: 7054-3039
Факс: 7054-3039
Тайлбар: _____
Тайлбар: _____

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Говьсүмбэр аймгийн ИТХ-ын хүсэлтийн дагуу
Төрийн аудитын тухай хуульд тодорхойлсон бүрэн
эрхийн хүрээнд 2014-2016 оны үйл ажиллагааны үр дүнд
хийгдсэн Гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй
танилцан саналаа хүргүүлж байна.

Хавсралт: 2 хуудас

ДАРГА  Ц.ЭНХБААТАР



C:\Users\Documents\2017\toot-A5.docx

**Аудитын гүйцэтгэлийн 2014-2016 оны үйл ажиллагааны
үр дүнгийн тайлангийн төсөлтэй холбогдох санал**

2017-06-30

Чойр

1. Аймгийн Аудитын байгууллагаас 2017-04р сарын 26-ны үдээс хойш шалгалтын удирдамжийг хүлээн авч 04р сарын 27-ны өдөр Анхан шатны 2014,2015,2016 оны бүх санхүүгийн баримт, холбогдох баримтуудыг нярав Г.Булгантай очин жагсаалтаар хүлээлгэн өгч, имайл хаягаар 2014,2015,2016 оны санхүүгийн баримтуудыг программаас, шаардсан баримтуудыг 05 сарын 04-ны өдрөөс эхлэн файлаар өгсөн ба байгууллагын даргатай 05-р сарын 23-ны өдөр дуудагдан очиж уулзан 05сарын 30-ны өдөр шалгуулж дуусаж 2017-06-29 ны өдөр дүгнэлтээ хүлээн авч хариу тайлбар саналаа хүргүүлж байна.
2. Байгууллагын бүтэц, орон тоо, зорилго, зорилтоо оновчтой тодорхойлон ажиллана. Бүтэц, зохион байгуулалтын хувьд аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын статустай 2 тайлан гаргадгаас нэг хуулиа нөгөө хуулиараа зөрчигдөн ажиллаж байгаа байдлыг нэг болгох шалгалт болсонд байгууллагын зүгээс талархалтай байна.
3. Ус худалдан борлуулсны орлогыг ОНО-д төвлөрүүлдэгийг бүртгээд, Ус худалдан авсны төлбөрийг тухайн байгууллагад төлөхөд орлогоосоо зарцуулах эрхгүй учраас Ус Ду –д бэлнээр / хассаар /төлсөн 3,9 сая / 14, 18, 19, 24-р хуудас ба хавсралтанд заасан / төгрөгийг актаар төлөх болсныг дахин нягталж зөвлөгөө өгч бидний ажилд тусална уу. Аймаг орон нутгийн ард иргэдийг ундны усан хангамжаар хангаж ажиллах үед манай байгууллагын гүний худаг ажиллахаа больж засварлах хөрөнгө мөнгө шийдэгдээгүйн улмаас АРД ИРГЭД-ийг ундны усны хангамжаар хангах шаардлагаар Ус Ду-гаас ус худалдан авч зохих төлбөрийг төлсөн билээ. Хойшид энэ байдал үргэлжлэх учраас Үүнийг актаар төлөх нь хүндрэлтэй тул актаас чөлөөлж өгнө үү.
4. 2014,2015,2016 онуудад нэмэлт санхүүжилтийн дансаар 14088,6 мян төгрөгийн материалыг орлогоор, зарлагаар бүртгэн авсан боловч бараа материалын тодруулга тайланд бараа материал татагдаагүйг цаашид нягтлан, залруулж ажиллах болно. /19-р хуудсанд /
5. ААН тайлан, орлогын тайлан дээр 4,538,808.6 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг бүртгэхэд Аж ахуйн тооцотой үйлдвэрээр ажиллах нөхцөл нь бүрдээгүй, ашигтай гарах тохисолдолд НӨТ төлөгч болох ба төлөх нөхцөл нь бүрдээгүй учраас мөн сангийн яаманд нэгтгэл хийхэд 2 тайлангаар хөрөнгө давхцан харагдах тул зөвхөн Төсвийн тайланд Хөрөнгө оруулалтын ажлыг 100 хувь бүртгэсэн болно.
6. 43,942.5 мянган төгрөгийн байгууллагад хамааралгүй хөрөнгө /22р хуудас, хавсралт-2 / үндсэн хөрөнгө бүртгэл нь АИТХ-ын тогтоол шийдвэрийн дагуу бүртгэсэн ба тухайн хөрөнгийг орлого авсан жилүүдийн тайлан балансад хавсаргаатай байгаа болно.
7. Үндсэн хөрөнгийн шинж чанартай 40990,5 мянг төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөнд бүртгэн ажиллана.
8. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2015-2016 оны батлагдсан төсвийг байршуулсан байсан боловч 2016 оны эхэнд цахим хуудсанд өөрчлөлт орох үед төсвийн мэдээлэл гүйцэд ороогүй байсныг нягтлаагүй байна. 2016 онд авсан 12,000,000 төгрөгийн тендерийн хөрөнгийг ил тод болгох огноо 2017 оны 1сард байсан тул 2017-01 сард мэдээлсэн. 2016 онд байхгүйгээр бүртгэсэн. Удирдлагын шинэчлэлтийг хийгээгүй байснаа залрууллаа. Цаашид Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллана.
9. Үндсэн үйл ажиллагааны орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлэхэд судалгаа, тооцооллыг хийж төлөвлөгөөгөө батлуулан ажиллана.

10. ААНБ, айл өрхийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж ажиллахаар Гүүк Софт ХХК-д "AXPLORER" санхүүгийн программын газар захиалгаа өгөн хийлгэж байгаа болно. Төлбөр тооцон дээр асуудалтай байна.
11. Байгууллагын зардал, үр ашгийн тооцооллыг хийж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх нөхцөл бололцоог эрэлхийлж ажиллана.
12. НББОУС-ыг мөрдлөг болгон ажиллана. Мөн зарим үндсэн хөрөнгүүдийг харьяалагдах байгууллагуудад шилжүүлэх асуудлыг холбогдох газруудад хүргүүлж шийдвэрлүүлнэ.
13. Дотоод хяналтын ажилтныг томилон шалгалт хийх журам дүрмийг боловсруулан ажиллана.

Тохижилт Сүмбэр ОНӨҮГазар

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР

Аймгийн “Тохижилт-Сүмбэр” ОНӨААТҮГ-аас ирүүлсэн саналтай танилцаад дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

2014-2016 онд ус борлуулсан болон хог хаягдал гаргасны хураамжийг кассад хураан авч бэлнээр зарцуулсан 3,972.3 мянган төгрөгийн орлогод тогтоосон актыг чөлөөлж өгөх санал ирүүлсэнийг хянан үзээд уг орлогоос усны төлбөрт зарцуулсан 3,332.5 мянган төгрөгийг актаас чөлөөлж, 639.8 мянган төгрөгөнд төлбөрийн акт тогтоохоор тайланд өөрчлөлт оруулж шийдвэрлэв.